

Г Уур амьсгалын өөрчлөлтийн талаар авах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд “Уур амьсгалын өөрчлөлтийн тулгамдсан асуудлууд, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний тухай Засгийн газраас ирүүлсэн холбогдох баримт материалтай ажлын журмаар танилцаад ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Их Хуралд:

1. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх бодлогыг шинэчлэн тодорхойлж эрх зүйн орчинг бүрдүүлэх,
2. УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд уур амьсгалын өөрчлөлт, түүнд дасан зохицохуйн салбар дундын бодлого, зохицуулалтыг нэмж оруулах.

Хоёр. Монгол Улсын Засгийн газарт:

1. Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийг хөгжлийн бусад бодлого, хөтөлбөртэй уялдуулан шинэчлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратегийг оновчтой томъёолон боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлэх,
2. Уур амьсгалын өөрчлөлтийн талаархи бодлогыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны харилцан уялдааг хангах асуудал хариуцсан бүтцийг байгуулж ажиллах.